



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 4 дүгээр сарын 12-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 64

Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь: 1.Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт-ыг хавсралт ёсоор
баталсугай.

2.Энэхүү техникийн зохицуулалтаар тогтоосон, үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан
согтууруулах ундаа импортоор нийлүүлж байхыг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт
үүрэг болгож 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны 11 дүгээр
сарын 21-ний өдрийн 162 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.ЭРДЭНЭБАТ